



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: oyungerels@
audit.gov.mn

Аудитор: Ж.Ядмаа
Утас: 261740
Цахим хаяг: j_yadmaa@yahoo.com

Монгол Улсын
Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-46
Бага тойруу-6

АГУУЛГА

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын санал дүгнэлт

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Оршил

Шадар сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын сул тал, үүсэх эрсдэл, хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитаар хөндөгдсөн асуудлуудыг дор нэгтгэн тайлбарлав.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс байгууллагын санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Шадар сайдын Ажлын албаны дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан түүврийн сорил гүйцэтгэж, шинжилгээ хийлээ. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- ❖ Онцгой байдлын ерөнхий газар авлагын үлдэгдлийг урьд оноос 40 хувиар бууруулсан хэдий ч удаан жил болсон найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой ажил хийгээгүй байна. Тухайлбал, Авлагын насжилтад хийсэн шинжилгээгээр 4 жилээс дээш хугацаатай 2,501.5 сая төгрөг, төлөгдөх найдваргүй болсон 1,404.2 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь нийт авлагын үлдэгдлийн 92.4 хувийг эзэлж байна.
- ❖ Онцгой байдлын ерөнхий газар нь 2013 оны төсөвт зардал 84,473.7 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 77,685.9 сая төгрөг гарч, 6,787.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Тухайлбал: 2013 онд нийт орон тоо 3909 байхаас гүйцэтгэлээр 3765 буюу 144 орон тоогоор дутуу ажилласнаас цалин, НДШ 944.6 сая төгрөг, дараа онд шилжигдсэн хөрөнгө оруулалтаас 1,790.0 сая төгрөг, үрийн буудай болон өвс тэжээлийн нөөцийг төлөвлөгөөний дагуу бүрдүүлж чадаагүйгээс 2,794.2 сая төгрөг, нийт 5,528.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.
- ❖ Онцгой байдлын ерөнхий газрын салбар, нэгжүүдийн 2013 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар 5,517.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаа нь дотоод хяналт үр нөлөөгүйг харуулж байна.
- ❖ МХЕГ-т хийсэн аудитаар нийт 21,498.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 6.7 сая төгрөгийн зөрчилд 9 акт тогтоож, 34.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага бичигдсэн, 20,512.8 сая төгрөгийн зөрчилд

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

49 зөвлөмж өгөгдсөн, 944.3 сая төгрөгийн 34 алдаанд залруулга хийгдсэн байна.

- ❖ Стандартчилал, хэмжил зүйн газрын салбарын хэмжээнд орон нутгийн хэлтсүүд өөрийн үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан, зарим зардлыг холбогдох шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсан зэрэг нийт 17.4 сая төгрөгийн зөрчлийг аудитаар илрүүлэн зөвлөмж өгсөн байна.
- ❖ Шадар сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 116 байгууллага хамрагдсан бөгөөд 108 байгууллагын санхүүгийн тайланд **зөрчилгүй**, 8 байгууллагын санхүүгийн тайланд **хязгаарлалттай** санал дүгнэлт өгсөн байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Эдгээр асуудал нь дээр дурдсан санхүүгийн дотоод хяналтын талаарх үнэлэлт менежментийн захидлын хамт илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж байгаа болно.

- Оюуны өмчийн газар арилжааны банкин дахь гадаад валютын харилцах дансаар олон улсын бараа тэмдэгтийг баталгаажуулсан гэрээт ажлын орлогыг хүлээн авч, тайлант оны эцэст уг дансанд 30.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд Сангийн яамнаас данс нээх талаар холбогдох зөвшөөрлийг аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн дансаар гүйцэтгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.
- Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тайлагналтай холбоотой 1.2 сая төгрөг, төсвийн мөнгийг зориулалт бусаар зарцуулсан 0.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж өглөө.
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан хэрэгцээнд ашиглаж буй суудлын 5 автомашины ашиглалтын хувийн хэргийг хөтлөөгүйгээс засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулахад хүргэсэн байна.
- Тус газрын өмч хамгаалах зөвлөлийн акт гараагүй байхад тус газарт ашиглагдаж байгаа Хьюндай соната NF маркийн 04-29 УНУ дугаартай автомашины мотор солиулахаар ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр хувь хүний дансанд 3.4 сая төгрөг шилжүүлж, зардалд тооцсон байна.
- 2013 оны эцэст үнэт цаасны үлдэгдлийг байцаагч нарт болон няравт хадгалагдаж байгаа тоо ширхэг, дугаараар тоолж, байцаагч нартай тооцоо хийж, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.
- ШӨХТГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэг удаагийн тэтгэмж, урамшууллын хэмжээг төсвийн байгууллагын жишиг, Засгийн газрын тогтоолоос өндөр хэмжээнд тогтоосноор 2013 онд нийт 9.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

- Үүнээс гадна тус байгууллага нь 2013 онд “Сарын тэргүүний ажилтан” шалгаруулах журам гаргаж сарын тэргүүний ажилтнаар 10 хүнийг, хамт олноо манлайлан ажилласан хэмээн нэр бүхий 5 хүнийг, шилдэг ажилтнаар 1 хүнийг тус тус шалгаруулан, нийт 8.0 сая төгрөгийн шагналыг жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.
- Стандартчилал, хэмжил зүйн газрын 2013 оны санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдэл нь оны эхнээс 30.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал: Түүхий эд материалын үлдэгдэл 11.4 сая, Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 5.4 сая, Хангамжийн материалын үлдэгдэл 13.2 сая төгрөгийн тус тус нөөцтэй байна. Цаашид дээрх үлдэгдлийн нөөцийг судалж, нормативт хэмжээнд байлгах нь зүйтэй байна.
- Санхүүгийн байдлын тайлан дахь бусдаас авах авлага 42.0 сая төгрөгийг 2008 оноос хойш тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно”, 9.1-д “ААН,байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж, данс бүртгэлд тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.
- МХЕГ-ын өр төлбөр өмнөх оноос 3.5 дахин буюу 34.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр үүсэхгүй байх” гэсэн заалтай нийцэхгүй байна.
- БНХАУ-ын Тяньжин хот дахь Төлөөлөгчийн газар нь “Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 313 дугаар тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж 4 жил болсон байна. 2013 оны санхүүгийн тайлангаар 14.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй боловч 2010 оноос хойш үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй байна.
- Улсын Их Хурлын ордон барих төслийн нэгж 2013 онд нийт 13.7 сая төгрөгийн санхүүжилт авч 2 сар үйл ажиллагаа явуулж, санхүүгийн тайланг гаргасан бөгөөд өрөө түрээслэсний төлбөрт 1.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Тус ТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагч 3, төвлөрүүлэн захирагч 3 байгууллагад хийгдсэн аудитын дүгнэлтийг товчлон үзүүлбэл:

Оюуны өмчийн газар:

Оюуны өмчийн газарт 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансаар өмнөх оны авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгч, “**Зөрчилгүй**” санал дүгнэлт өгсөн.

Худалдан авах ажиллагааны газар:

Худалдан авах ажиллагааны газарт 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансаар мөнгөн хөрөнгийн талаарх зөрчлийг засч арилгуулах талаар зөвлөмж өгч, “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргасан.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар:

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2013 оны санхүүгийн тайлан балансаар үнэт цаасны бүртгэлийн хөтлөлт, тайлан тооцооны талаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Онцгой байдлын ерөнхий газар:

Онцгой байдлын ерөнхий газрын 2013 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар авлагыг хураан барагдуулах талаар зөвлөмж өгч, “Зөрчилгүй” саналдүгнэлт өгсөн байна.

Стандартчилал, хэмжил зүйн газар:

Стандартчилал, хэмжил зүйн газрын 2013 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж өгч, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2013 оны төсвийн гүйцэтгэлээр тэвчиж болох зарим зардал 0.2-18.5 сая төгрөг, эд хогшлын зардал 7.8 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсөвт зардлаас хэтэрсэн, 20,512.8 сая төгрөгийн тайлагналын зөрчилтэй байсан зэргийг үндэслэн “Хязгаарлалтай” санал дүгнэлт өгсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Шадар сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 680

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД Д.ТЭРБИШДАГВА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, аргачлалын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

070441



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШАДАР САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Төсвийн хөрөнгийн зарцуулалтын
талаар

Асуудал 2 Авлагын талаар

Асуудал 3 Үндсэн хөрөнгийн элэгдлийн
талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Шадар сайдын Ажлын албаны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол Удсын Шадар сайдын Ажлын албаны удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 1: Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол
№1

ҮАГ-ын ажиглалт

ШӨХТГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэг удаагийн тэтгэмж, урамшууллын хэмжээг төсвийн байгууллагын жишиг, Засгийн газрын тогтоолоос өндөр хэмжээнд тогтоосноор 2013 онд нийт 9.1 сая төгрөгийн зардал гарсан байна. Үүнээс гадна тус байгууллага нь 2013 онд “Сарын тэргүүний ажилтан” шалгаруулах журам гаргаж сарын тэргүүний ажилтнаар 10 хүнийг, хамт олноо манлайлайн ажилласан хэмээн нэр бүхий 5 хүнийг, шилдэг ажилтнаар 1 хүнийг тус тус шалгаруулан, нийт 8.0 сая төгрөгийн шагналыг жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд зөрчигдөх,

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах гэж заасныг мөрдөж ажиллах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 2: Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Онцгой байдлын ерөнхий газар авлагын үлдэгдлийг урьд оноос 40 хувиар бууруулсан хэдий ч удаан жил болсон найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой ажил хийгээгүй байна. Тухайлбал, Авлагын насжилтад хийсэн шинжилгээгээр 4 жилээс дээш хугацаатай 2,501.5 сая төгрөг, төлөгдөх найдваргүй болсон 1,404.2 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь нийт авлагын үлдэгдлийн 92.4 хувийг эзэлж байна. зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.8- “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах,

Авлагын тооцоо нийлж актаар баталгаажуулж байх,
Найдваргүй авлагыг хууль, хяналтын байгууллагаар *шийдвэрүүлэх,*

Эрсдэлүүд

Бодит бус өр төлбөр, авлага үүсгэсэн ба авлага, өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

**Тэргүүлэх ач
холбогдол №1**

ҮАГ-ын ажиглалт

БНХАУ-ын Тяньжин хот дахь Төлөөлөгчийн газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар 14.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй боловч үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын заалтыг мөрдөж ажиллах,

Эрсдэл

Үйл ажиллагааны дүн буруу тайлагдах,
Тайлан тооцоо буруу гарах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

СТ-1А

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,307,600,651.20	1,360,464,467.85
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,034,735.72	9,370,388.40
Төгрөг\ ЖМС	929,459.93	9,265,112.61
Гадаад валют	105,275.79	105,275.79
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,306,565,915.48	1,351,094,079.45
Төгрөг	1,306,565,915.48	1,351,094,079.45
Орон нутгийн харилцах	24,419,800.00	-
Төсөвт байгууллагын харилцах	141,461,582.00	-
Тусгай зориулалтын сангийн харилцах	1,127,698,507.21	821,210,905.00
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	12,986,026.27	50,176,992.25
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	479,706,182.20
АВЛАГА	7,386,351,298.35	4,547,204,808.41
Ажиллагчидтай холбогдсон авлага	4,566,132.25	8,738,508.25
Төлбөртэй үйлчилгээний авлага	49,740,592.00	26,819,359.00
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	2,340,367,970.00	155,861,392.41
Бусад авлага	4,991,676,604.10	4,355,785,548.75
Байгууллагаас авах авлага	4,830,212,549.29	4,200,478,935.87
Гэрэл цахилгааны авлага	-	1,300,200.00
Түлш халаалтын авлага	-	21,754.00
Дотоод албан томилолтын авлага	1,150,800.00	891,502.00
Эмийн авлага	-	2,522,920.00
Бусад зардлын тооцооны авлага	4,829,061,749.29	4,195,742,559.87
Хувь хүмүүсээс авах авлага	161,464,054.81	155,306,612.88
УРЬДЧИЛГАА	306,125,882.43	156,522,288.27
Бусад урьдчилгаа	306,125,882.43	156,522,288.27
Урьдчилгаа тооцоо	-	1,082,877.00
Цалингийн урьдчилгаа	-	1,082,877.00
Урьдчилж гарсан зардал	306,125,882.43	155,439,411.27
Урьдчилж төлсөн зардал	306,125,882.43	155,439,411.27
БАРАА МАТЕРИАЛ	18,132,002,766.22	24,494,101,867.16
Түүхий эд материал	6,100,594,530.75	8,774,059,895.43
Тусгай зориулалттай материал	5,580,849,338.47	8,056,647,011.56
Эм боох материал	275,659,938.75	296,443,419.23
Дуусаагүй үйлдвэрлэл	2,612,497.32	158,400,879.21
Бэлэн бүтээгдэхүүн	241,472,756.21	262,568,585.43
Хангамжийн материал	11,934,532,133.51	15,591,124,263.67

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Бичиг хэргийн материал	197,530,678.81	209,438,273.45
Аж ахуйн материал	1,900,344,669.38	2,454,196,557.54
Сэлбэг хэрэгсэл	312,875,660.45	566,593,872.50
Түлш, шатах тослох материал	134,101,914.67	157,326,843.35
Барилгын засварын материал	45,033,450.90	20,187,698.76
Хүнсний материал	26,137,550.00	23,203,469.00
Малын тэжээл	9,817,500.00	-
Баглаа боодол	6,863,255.62	10,308,700.62
Бусад бараа материал	9,301,827,453.68	12,149,868,848.45
Мал амьтад	62,658,799.85	61,850,549.85
Бусад	34,217,302.11	67,067,158.21
НӨӨЦ	55,334,394,317.91	53,247,144,204.79
Барааны нөөц	21,931,354,120.51	24,063,957,135.00
Үрийн нөөц	11,148,104,586.75	6,017,475,329.80
Шатахууны нөөц	16,323,143,565.35	18,866,300,422.05
Бусад нөөц	5,931,792,045.30	4,299,411,317.94
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,466,474,916.11	83,805,437,636.48
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	64,056,181,371.28	110,543,091,761.64
Биет хөрөнгө	63,820,166,182.81	110,279,348,513.51
Барилга, байгууламж, орон сууц	32,994,933,727.37	51,548,997,903.25
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	64,561,486,476.44	84,331,174,151.44
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(31,566,552,749.07)	(32,782,176,248.19)
Авто-тээврийн хэрэгсэл	7,201,216,099.40	21,557,718,443.10
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	15,227,399,722.77	31,413,754,824.24
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(8,026,183,623.37)	(9,856,036,381.14)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,493,714,108.37	20,120,977,151.71
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	25,482,596,799.08	36,522,952,298.77
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(13,988,882,690.71)	(16,401,975,147.06)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,364,481,354.98	3,578,776,708.33
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	4,862,250,025.74	6,438,314,170.19
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(2,497,768,670.76)	(2,859,537,461.86)
Зам, гүүрийн байгууламж	174,880,773.67	167,641,053.09
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	192,453,669.00	200,103,669.00
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(17,572,895.33)	(32,462,615.91)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,517,426,326.76	1,452,700,208.75
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Анхны өртөг	3,269,895,641.55	3,447,198,485.44
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Хуримтлагдсан элэгдэл	(1,752,469,314.79)	(1,994,498,276.69)
Бусад үндсэн хөрөнгө	1,219,072,418.11	3,090,045,495.13
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	2,895,919,268.42	4,982,171,248.60
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(1,676,846,850.31)	(1,925,996,036.47)

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Номын фонд	-	33,870,283.00
Дуусаагүй барилга, байгууламж	6,854,441,374.15	8,762,491,550.15
Биет бус хөрөнгө	236,015,188.47	263,743,248.13
Програм хангамж	201,717,567.25	234,669,700.86
Програм хангамж - Анхны өртөг	571,907,792.23	639,836,829.21
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(370,190,224.98)	(405,167,128.35)
Бусад биет бус хөрөнгө	34,297,621.22	29,073,547.27
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	57,933,150.00	59,040,650.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(23,635,528.78)	(29,967,102.73)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	146,522,656,287.39	194,348,529,398.12
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,290,628,862.23	1,529,839,723.19
Өглөг	1,290,628,862.23	1,529,839,723.19
Ажилчидтай холбогдсон тооцоо	6,268,607.00	16,901,739.81
Цалингийн өглөг	2,434,038.00	5,264,227.01
НДШ-ийн өглөг	105,956.00	3,112,910.29
ХАОАТ-ын өглөг	3,728,613.00	8,524,602.51
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	5,893,218.76	58,252,740.07
Гэрэл цахилгааны тооцоо	326,873.00	25,000.00
Түлш халаалтын тооцоо	-	10,361,842.00
Шуудан холбооны тооцоо	48,507.30	554,276.20
Цэвэр, бохир усны тооцоо	-	(20.00)
Тээвэр шатахууны тооцоо	3,500,000.00	12,681,640.00
Эмийн тооцоо	-	16,340,442.47
Бусад зардлын тооцоо	2,017,838.46	18,289,559.40
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	1,044,540,745.00	736,634,570.00
Бусад өглөг	233,926,291.47	718,050,673.31
Байгууллагад төлөх өглөг	224,149,334.73	706,698,312.08
Хувь хүмүүст төлөх өглөг	9,776,956.74	11,352,361.23
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,290,628,862.23	1,529,839,723.19
Засгийн газрын хувь оролцоо	145,232,027,425.16	192,818,689,674.93
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	96,753,992,726.30	96,753,992,726.30
Хуримтлагдсан үр дүн	29,175,433,050.96	76,973,061,750.62
Өмнөх үеийн үр дүн	29,175,433,050.96	25,150,221,629.80
Тайлант үеийн үр дүн	-	51,822,840,120.82
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,302,601,647.90	19,091,635,198.01
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	145,232,027,425.16	192,818,689,674.93
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	146,522,656,287.39	194,348,529,398.12

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

СТ-2А

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,804,369,920.96	126,786,600,182.38
Гадаад орнуудаас үзүүлсэн	36,515,017.50	-
Урсгал	36,515,017.50	-
Олон улсын байгууллагын тусламж	-	5,147,736.00
Урсгал тусламж	-	5,147,736.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	105,767,854,903.46	126,781,452,446.38
Улсын төвлөрсөн төсвөөс	96,987,251,034.72	126,073,070,114.78
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	82,464,949,363.52	81,047,590,908.51
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	469,785,468.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	5,475,166,966.20	6,055,425,419.63
Хөрөнгийн	9,047,134,705.00	32,027,149,266.80
Тусламжийн сангаас санхүүжих	-	18,101,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,455,018,051.84
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	768,329,058.01
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	5,136,971,859.98
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	441,456,183.85
Төсвийн урамшуулал	-	108,260,950.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	2,322,642,056.00	593,583,796.60
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	115,169,420.00	166,151,700.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,207,472,636.00	242,355,300.00
Төсвийн хуваарилаагүй зардал	-	5,000,000.00
Хөрөнгийн	-	180,076,796.60
Төсөвт байгууллагаас	6,428,189,724.74	36,277,977.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,955,222,467.74	36,277,977.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	275,000,000.00	-
Үдийн цай санхүүжилтийн орлого	3,195,959,251.00	-
Хөрөнгийн	2,008,006.00	-
Нийгмийн даатгалын сангаас	29,772,088.00	78,520,558.00
НДС-ийн шилжүүлэг	27,696,701.00	68,184,539.00
ЭМДС-ийн шилжүүлэг	2,075,387.00	10,336,019.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,994,541,899.66	101,197,150,454.41
Өмчийн орлого	-	149,828,200.00
Хүүгийн орлого	-	149,828,200.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	17,986,236,801.69	28,252,876,261.89
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	17,983,078,152.11	28,250,435,433.71
Үндсэн үйл ажиллагааны орлого	12,578,197,776.65	15,996,355,327.63
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,233,842,751.39	8,504,557,450.23
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	288,706,359.80	657,229,186.21
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,882,331,264.27	3,092,293,469.64
Захиргааны хураамж	3,158,649.58	2,440,828.18
Бусад захиргааны хураамж	3,158,649.58	2,440,828.18

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Торгууль, шимтгэл	171,328,424.00	-
Тусламжаас бусад шилжүүлэг	31,836,976,673.97	25,826,246,330.26
Зээлийн орлого	31,836,976,673.97	25,826,246,330.26
Шинээр олголт	31,836,976,673.97	25,826,246,330.26
Татварын бус бусад орлого	-	46,968,199,662.26
Хөрөнгийн орлого	-	39,512,115,271.47
Ангилалдаагүй орлого	-	7,456,084,390.79
Ангилалдаагүй бусад орлого	-	7,456,084,390.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	155,798,911,820.62	227,983,750,636.79
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	51,168,929,873.57	57,168,208,372.12
Үндсэн болон нэмэгдэл цалин	48,224,920,992.13	53,883,722,664.09
Үндсэн цалин	45,181,795,567.54	50,915,159,141.20
Гэрээт ажилчдын цалин	1,685,039,690.32	1,762,231,355.89
Унаа хоолны хөнгөлөлт	899,237,500.06	432,658,221.00
Бусад нэмэгдлүүд	458,848,234.21	773,673,946.00
Үр дүнгийн урамшуулал	-	269,955.00
Унаа, болон бусад нөхөн олговор	352,847,198.21	631,182,588.00
Бусад нэмэгдэл	106,001,036.00	142,221,403.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	2,944,008,881.44	3,284,485,708.03
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	2,066,699,216.53	1,853,120,067.26
Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,695,969,962.51	1,489,087,292.42
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	95,157,681.51	141,270,721.52
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	182,851,049.52	165,552,250.77
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	92,720,522.99	57,209,802.55
Эрүүл мэндийн даатгалын хураамж	877,309,664.91	1,431,365,640.77
УРСГАЛ ЗАРДАЛ	53,874,995,293.52	71,807,846,269.89
Бараа үйлчилгээний урсгал зардал	40,965,855,755.36	42,056,676,547.98
Тогтмол зардал	2,372,706,295.14	2,649,685,078.49
Гэрэл цахилгаан	436,987,628.69	530,318,185.10
Түлш, халаалт	1,755,737,953.86	1,911,828,019.73
Цэвэр, бохир ус	179,980,712.59	207,538,873.66
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	868,467,563.30	1,166,311,949.91
Хоол	471,678,134.10	682,859,410.49
Эм, вакцин	396,789,429.20	483,452,539.42
Бусад бараа үйлчилгээний зардал	37,724,681,896.92	38,240,679,519.58
Бичиг хэргийн зардал	449,947,299.20	440,732,740.36
Тээвэр, шатахуун	1,873,559,450.81	2,918,695,863.50
Шуудан, харилцаа холбоо	318,791,241.81	347,582,999.31
Дотоод албан томилолт	1,211,568,350.02	1,155,310,539.73
Гадаад албан томилолт	152,206,048.00	203,700,596.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	29,407,643.90	18,748,940.82
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	204,806,281.06	310,541,509.56
Сургалт семинарын зардал	127,271,659.62	364,423,603.90
Эрдэм шинжилгээний ажил хийх	71,226,491.98	139,473,244.56
Жижиг эд хогшил худалдан авах	47,497,470.03	117,537,255.61
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	19,367,861.41	60,285,008.71
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	285,850.00	-

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	-	12,895,592.00
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	27,843,758.62	44,061,654.90
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	-	295,000.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	585,720,479.58	4,248,633,501.43
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,404,719,778.30	1,596,032,817.42
Харуул, хамгаалалтын зардал	433,466,667.33	24,854,208.00
Банкны үйлчилгээний хураамж	8,700.00	7,600,860.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	318,577,928.87	331,802,592.21
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	318,577,928.87	330,691,592.21
ТӨГАУ \Харуул, хамгаалалтын хөлс \	-	1,020,800.00
ТӨГАУ \Тээврийн хэрэгслийн оношилгоо\	-	90,200.00
Маягт хэвлүүлэх зардал	298,967,447.82	207,519,314.76
Урсгал засвар	1,304,125,467.53	1,247,517,318.20
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	86,937,301.00	146,878,879.98
Гадаадын зочны зардал	44,739,075.10	44,077,958.00
Бусад зардал	4,699,033,721.28	285,264,011.35
Засварын зардал	17,169,921,041.97	15,054,930,466.50
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,294,413,728.43	8,574,788,672.18
Аж ахуйн материал худалдан авах зардал	61,503,977.00	10,468,594.17
Бараа материал акталсны зардал	516,756,846.28	439,351,865.95
Газрын төлбөр	7,547,800.00	3,111,166.08
Улсын мэдээллийн маягтын зардал	10,860,000.00	-
Товхимол, тараах материал	1,100,000.00	1,100,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	12,909,139,538.16	29,751,169,721.91
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	5,656,753,157.15	19,705,050,104.58
Мал аж ахуйн үржлийн зардал	1,858,000.00	2,061,000.00
Дотоодын уралдаан, тэмцээний зардал	-	1,500,000.00
Бүтцийн өөрчлөлтийн урсгал зардал	-	182,771,016.00
Улсын нөөцийн бараа худалдан авах зардал	4,508,891,084.19	18,691,578,671.50
Хүнсний бүтээгдэхүүн бараа	190,581,434.09	1,087,773,543.48
Үрийн будаа	766,389,132.63	932,854,312.83
Өвс тэжээлийн нөөц	2,420,485,156.39	4,165,006,411.78
Шатахууны нөөц	885,568,631.26	2,220,098,464.45
Эм, эмнэлэгийн хэрэгсэл	3,932,648.39	-
Таваарын буудайн нөөц	5,156,850.00	5,423,016,928.57
Машин, техникийн нөөц	236,777,231.43	4,862,829,010.39
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	78,911,655.00	135,430,518.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	666,713,157.24	359,947,542.30
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	290,092,024.72	287,532,386.34
Улсын төсвөөс ой тэмдэглэхэд олгох	103,156,700.00	-
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	7,130,536.00	44,228,970.44
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	4,969,536.00	43,205,470.44
Сургалт, семинар зохион байгуулах зардал	2,161,000.00	1,023,500.00
Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал	16,283,638.00	40,764,708.66

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/	6,755,756,334.43	8,159,704,068.30
Улс орны болон бүс нутгийн чанартай байгалийн гамшиг, үр дагаварыг арилгах	2,536,435,518.57	3,880,682,128.30
Нийтийг хамрах аюул бүхий гоц халдварт өвчний голомтыг арилгах, түр хязгаарлах	4,129,607,145.86	4,258,714,204.00
Бусад төсөл арга хэмжээ	89,713,670.00	20,307,736.00
Баяр наадмын зардал	9,029,570.00	-
Шагнал, тэтгэмжийн зардал	261,000.00	2,010,000.00
Бусад	80,423,100.00	18,297,736.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	446,070,670.40	1,819,217,781.87
Бусад төсөл арга хэмжээ	446,070,670.40	1,814,684,981.87
Бусад нэр төрлийн хуваарилагдаагүй	-	4,532,800.00
Болзошгүй эрсдлийг нөхөх зардал	34,275,738.18	26,433,058.50
